



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/63

Бор-Өндөр

**Эрсдэлийн сангаас хөрөнгө зарцуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2025 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/136 дугаар захирамж, Бор-Өндөр сумын Онцгой комиссын 2025 оны 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажил болон гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд “Багаж техник хэрэгслийн засварын зардал”-д 919,000 (есөн зуун арван есөн мянга) төгрөг, шатахууны зардалд 1,237,000 (нэг сая хоёр зуун гучин долоон мянга) төгрөг, бараа материал, бичиг хэргийн зардалд 1,000,000 (нэг сая) төгрөг, нийт 3,156,000 (гурван сая нэг зуун тавин зургаан мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Зардалд зарцуулагдах 3,156,000 (гурван сая нэг зуун тавин зургаан мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Эрсдэлийн сангаас зохих журмын дагуу тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г А Д Ъ Я А Б И Л Э Г Т